



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/622

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/383 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, 2019 онд батлагдан гарсан хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангах ажлын хэсгийг 1 дүгээр, зохион байгуулах ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу үйл ажиллагааг чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж дүнг, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/622 Ch
02 03095



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагааны холбогдох стандарт шаардлагыг мөрдүүлэх, гадна тоглоомын талбайн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн

| | | |
|---------|----------------|---|
| ахлагч: | Б.Даваадорж | -Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Гишүүд: | М.Пүрэвхүү | -Боловсрол, соёл, урлагийн газрын дарга |
| | П.Эрдэнэчулуун | -Мэргэжлийн хяналтын газрын дарга |
| | Б.Батзаяа | -Цагдаагийн газрын дарга |
| | Б.Алтанбадралт | -Онцгой байдлын газрын дарга |
| | Ц.Мягмарсүрэн | -Эрүүл мэндийн газрын дарга |
| | Б.Эрдэнэцэцэг | -Стандарчилал хэмжил зүйн газрын дарга |
| | С.Гантөмөр | -Жаргалант сумын Засаг дарга |
| | М.Оюунсүрэн | -Хүүхэд хамгаалагч |
| | М.Бямбажав | -Хүүхэд хамгаалагч |

Ажлын хэсгийн нарийн

бичгийн дарга: Ц.Номинчимэг -Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

-oOo-



УДИРДАМЖ

“Хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх” тухай

Зорилго:

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор эрчимжүүлэх, бүх түвшинд хүүхдийг аливаа осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг мөрдүүлэх

Үйл ажиллагааны чиглэл:

-Баг, байгууллага, сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, замын далан, ухсан нүх, цооног, суваг шуудуу, траншей, муу усны нүх, худаг орчимд анхааруулах тэмдэг байршуулах, таглаж битүүлэх

-Гадна орчны камержуулалтыг сайжруулах, сумдын хамтарсан багт сэрэмжлүүлэг, санамж, зөвлөмж өгөх

-Эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлага, хүүхэддээ тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, бага насны хүүхдийг харгалзах насанд хүрсэн хүнгүйгээр гэрт үлдээх цоожлох зэрэг санамсар болгоомжгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажил зохион байгуулах

-Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, асран хамгаалагч, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах

-Цэцэрлэг, сургууль хүүхдийн байгууллагын байрнаас 100 метр зайд архи, тамхи, согтууруулах ундаах удалдахгүй, үйлчлэхгүй байх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах, хаах, хүртэл арга хэмжээ авах.

-Хүүхдийн тоглоомын байгууламж болон гадна тоглоомын талбайн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангах, засвар үйлчилгээний байдалд хяналт хийж зөвлөмж хүргүүлэх

-Сургууль, цэцэрлэг, баг, албан байгууллагын ойр орчимд хүүхдийн орчны аюулгүй байдалд хяналт хийх багийг иргэдийн оролцоотойгоор байгуулж үнэлгээг гарган холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх

Хугацаа: 2019 оны 10 сарын 01-нээс 11 сарын 01 хүртэл

Хэрэгжүүлэгч байгууллага: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Стандарчлал хэмжил зүйн газар, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, Хүүхэд хамгаалагч нар.

Хүлээгдэж буй үр дүн: - Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт хангагдсан байна.

- Хүүхэддээ тавих эцэг эхчүүдийн анхаарал, хараа хяналт сайжирсан байна.
- Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаар төрийн байгууллагуудын хандлага сайжирсан байна.
- Сургууль, цэцэрлэг, төрийн байгууллагуудын орчимд хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна.
- Сургууль, цэцэрлэг, худаг гэх мэт хүүхэд ихээр явдаг газруудад тэмдэг тэмдэглэгээ тавигдсан байна.

-oOo-